

## СУДАЛГААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот

2007.03.12

### **1. Судалгааны сэдвийн томъёолол:**

ННФ-аас дэвшүүлсэн: Хүнсний аюулгүй байдал: Хүнсний стандартууд, импортын болон дотоодын үйлдвэрийн хүнсний барааг урамшуулах болон эс урамшуулах арга хэрэгсэл, хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга зам

Тодотгосон: Хүнсний аюулгүй байдал – Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хяналт

### **2. Судалгааны асуудал:**

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед манай улс хүнсний хэрэгцээнийхээ ихэнх хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, хуучнаар ЗХУ-аас багахан хэсгийг нийлүүлж байсан үе 1990 оноор дуусгавар болсон. Тэр үед хүнсний аюулгүй байдал харьцангуй баталгаатай байв.

Харин 1990 оноос хойш дотоодын хүнсний үйлдвэрлэл бараг бүрэн зогсож, улс оронд хүнсний хомсдол үүсч, хангамжийн хувьд баталгаагүй болж байсан билээ. Энэ байдлыг харгалзан тухайн төр, засгаас хүн амыг хүнсээр хангах, хангамжийг нэмэгдүүлэх, тогтвортой байлгахад гол бодлогоо чиглүүлж ирсэн. Энэ бодлогын үр дүнд өнөөдөр хүнсний хангамж, хэрэгцээ шийдвэрлэгдэж байгаа ч хүнсний чанар, аюулгүй байдал тулгамдсан асуудлын нэг болоод уджээ.

Монгол улсын Засгийн газраас хүнсний аюулгүй байдлын талаар баримталж буй бодлого, хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүд нь хүсэн хүлээж, төсөөлж байсан үр дүндээ хүрэхгүй, дорвитой өөрчлөлт хийгдэхгүй, ялангуяа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын үйл явцад хэрэгжүүлж буй хяналт, шалгалтын үйл ажиллагаанд тодорхой ахиц, дэвшил гарахгүй байгаа зэрэг байдал ажиглагдаж байна. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа сул байгаагаас чанар, аюулгүй байдлын баталгаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн их хэмжээгээр импортлогдож байна. Тухайлбал: Улсын мэргэжлийн хяналтын газрын Нэгдсэн төв лабораторийн тайлангаас үзэхэд манай улс 2003-2005 онд жилд дунджаар 31 нэр төрлийн 550 орчим мянган тонн хүнсний бүтээгдэхүүн импортлож, 40 гаруй хувийг хил, гүний мэргэжлийн хяналт, лабораторийн шинжилгээнд хамруулсан байна. Лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтад хамрагдсан бүтээгдэхүүний 8 хувь нь “шаардлага хангахгүй” гэсэн дүнтэй гарчээ. Үүнийг нийт бүтээгдэхүүний хэмжээтэй харьцуулбал 20 орчим хувь нь шаардлага хангахгүй гэсэн тооцоо гарч байна. Гэхдээ өнөөгийн лабораторийн түвшин, шинжилгээний чадавхитай холбон авч үзвэл импортын хүнсний

бүтээгдэхүүний 50 орчим хувь нь шаардлага хангахгүй, баталгаагүй байх магадлалтай гэж судлаач үзэж байгаа юм.

Иймд импортын хяналт, шалгалт, баталгаажуулалтын өнөөгийн тогтолцоо, үйл ажиллагааг нарийвчлан судлан, дүн шинжилгээ хийж, бодлогын хувилбар, зөвлөмж боловсруулах нь тулгамдсан асуудлын нэг гэж үзэж байна.

### **3. Судалгааны асуулт :**

Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлага хангагдахгүй байгаа учир шалтгаанаас хамгийн гол гэж үзсэнийгээ сонгон судалгааны асуултыг тодорхойлов. **“Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хяналт, шалгалт, баталгаажуулалтын өнөөгийн тогтолцоог шинэчилж, үйл ажиллагааг зохицуулснаар импортын хүнсний чанар, аюулгүй байдал хангагдах нөхцөл бүрдэж чадах уу?”**

### **4. Судалгааны таамаглал/гипотез/:**

Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлага хангагдахгүй байгаа учир шалтгаан нь хяналт, шалгалт, баталгаажуулалтын өнөөгийн бүтэц, тогтолцоо, үйл ажиллагаа идэвхгүй, сул, ялангуяа лабораторийн түвшин, шинжилгээний чадавхи муу байгаа явдал юм. **“Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хяналт, шалгалт, баталгаажуулалтын өнөөгийн тогтолцоог шинэчилж, үйл ажиллагааг зохицуулснаар импортын хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах нөхцөл бүрдэнэ” хэмээн таамаглаж байна.**

### **5. Судалгааны зорилго ба зорилт**

Энэхүү судалгаа зорилго нь Монгол орны хүнсний хангамж импортоос хамааралтай байгаа өнөөгийн нөхцөлд импортын хяналт, шалгалт, баталгаажуулалтын бүтэц, тогтолцоог шинэчлэх, үйл ажиллагааг нарийн зохицуулах боломжийг судлах, бодлогын зөвлөмж боловсруулахад оршино.

Дээрх зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хүнсний аюулгүй байдлын талаарх төрөөс баримталж, хэрэгжүүлж буй бодлого, үйлчилж ирсэн бодлогын баримт бичиг, хууль эрхзүйн актуудыг үндэслэн тоймлох,

2. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хяналт, шалгалтын олон улсын жишээ, туршлагыг судлах,

3. Өмнө хийгдсэн болон судалгааны хүрээнд явуулах ярилцлагуудын дүнг үндэслэн импортын хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулахад саад болж буй гол гол хүчин зүйлийг илрүүлэх,

4. Импортын хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах арга замыг эрэлхийлэх, харьцуулан үнэлэх, дүн шинжилгээ хийх

5. Дээрх зорилтуудын үр дүнг нэгтгэн импортын хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулахад чиглэсэн бодлогын хувилбаруудыг гаргаж, бодлогын зөвлөмж бэлтгэнэ.

## **6. Судалгаа шинжилгээ хийх нэгж, хувьсагч**

Төр засгийн бодлого, чиглэл, хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, гадаад орнуудын туршлага зэрэг нь судалгаа, шинжилгээний нэгж болно. Үүнээс гадна бодит нөхцөл байдлыг тодорхойлохын тулд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нэвтэрдэг гол 3 боомт болох Замын-Үүд, Алтанбулаг, Сүхбаатарыг сонгон авсан болно.

Урьдчилсан байдлаар импортын хүнсний чанар, аюулгүй байдалд нөлөөлж буй гол хүчин зүйлүүдийг багцлан тодорхойлбол:

1. Ядуурал, ажилгүйдэл нь чанар муутай, хямд үнэтэй хүнс хэрэглэх үндсэн нөхцөл болж байна.

2. Өнөөгийн хяналт, шалгалтын бүтэц, тогтолцоо, үйл ажиллагаа идэвхгүй, сул байгаа нь чанаргүй, хямд үнэтэй, баталгаагүй хүнс орж ирэх нөхцлийг бүрдүүлж байна.

3. Хүнсний бүтээгдэхүүний импортыг иргэн, хувь, хүмүүс олноор эрхэлж байна.

4. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг тодорхойлох лабораторийн түвшин, шинжилгээний чадавхи хангалтгүй байна.

5. Төрийн байгууллагуудын тэр дундаа хилийн хяналт шалгалтын байгууллагуудын ажлын уялдаа, холбоо муу байна.

6. Хэрэглэгчдэд хүнсээ сонгох, хүнсний аюулгүй байдалтай холбоотой мэдлэг, мэдээлэл хүргэх үйл ажиллагаа хэвшээгүй, дутагдалтай байна.

## **7. Судалгааны арга зүй**

Судалгаанд хоёрдогч эх үүсвэрийн мэдээлийг голлон ашиглахаас гадна экспертний болон фокус группын ярилцлага, гадаад орны туршлагыг судлах аргыг хэрэглэнэ.

1. Импортын хүнстэй холбоотой ном, хэвлэл, нийтлэл, хууль эрхзүйн баримт бичиг, хэрэгжсэн болон хэрэгжиж буй хөтөлбөр, төслийн тайлан, мэдээ, судалгаа шинжилгээний тайлан, илтгэл, оролцогч талуудын хэлсэн үг, уулзалт, семинарын баримт бичиг зэрэг эх сурвалжуудыг уншиж танилцан судалж шинжилнэ.

2. Судалж байгаа асуудлаар экспертүүдтэй ярилцлага зохион байгуулж, тэдний санал, дүгнэлтийг судлан бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглана. Үүнд: ХХААЯ-ны болон УМХГ-ын удирдах албан тушаалтан, мэргэжилтэн, байцаагчид болон бусад оролцогч талуудын төлөөлөл гэх мэт

3. Импортын хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулахад юу нөлөөлж байгааг тогтоох, цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай, ялангуяа импортын хүнсний талаар баримтлах бодлогыг тодруулах зорилгоор фокус бүлгийн ярилцлагыг бүтэцлэгдсэн байдлаар зохион байгуулна. Ярилцлагад ХХААЯ, УМХГ, Монголын Хүнсчдийн Холбоо,



хураангуйг дуусгаж танилцуулах	Судалгааны дүн шинжилгээний хураангуйг эцэслэн боловсруулж дуусгах									x	x
--------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	---	---

Төлөвлөгөө боловсруулсан:

Хүүхэнбаатарын ГАНЗОРИГ